

ТҮҮХТ ХҮМҮҮС

**ДИЛАВ ХУТАГТ: ҮЗЭЛ БОДОЛ,
ҮЙЛ АМЬДРАЛ**

(1884—1964)*

Ц. Пунцагноров

XX зууны эхэн үеийн Монголын шашин, төрийн зүтгэлтэн Дилав хутагт Жамсранжав үйл амьдралын ээдрээтэй бөгөөд урт удаан замыг туулжээ. Монгол орон манжийн Чин гүрний дарлалд байсан тэр үед Жамсранжав Баруун Монголд нөлөө бүхий хувилгаан болон тодорч манжийн ноёрхолыг түлхэн унагаж богд хаант Монгол улс байгуулагдсаны дараа улс төрийн тавцанд гарч иржээ. Тэрээр 1921 оноос хойш улс орны тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэхэд чиглэсэн ардын засгийн бодлогыг дэмжиж байсан боловч орон даяар өрнөсөн хувьсгалт өөрчлөлтийг тэр бүр таашаан үздэггүй байв. 1930-аад оны эхээр Дилав хутагт эх орноосоо дүрвэн гарч амьдралынхаа 30 гаруй жилийг Хятад, АНУ-д өнгөрөөжээ.

Дилав хутагт Жамсранжав монгол, төвд бичиг үсэгтэй, үндэснийхээ түүх соёлыг сайн мэддэг, шашны ном сургаалыг гүнзгий судалсан өргөн мэдлэгтэй хүн байжээ. Тэрээр үндэснийхээ эрх ашгийг ямагт эрхэмлэдэг, холч мэргэн ухаантай, хашир болгоомжтой улс төрийн зүтгэлтэн байсныг нь түүхийн баримт гэрчилж байна.

Энэхүү өгүүлэлдээ Дилав хутагтын үзэл бодол, улс төрийн үйл ажиллагааны шинж төлөвийг бүхэлд нь тоймчлон харуулах гэж оролдсоноо өчсү. Үүнд хутагтын өөрийн нь бичсэн улс төрийн дуртгал, намтар², Дилав хутагттай олон жил дотно нөхөрлөж хамтран ажилласан АНУ-ын гарамгай эрдэмтэн Оуэн Латтиморын ажиглалт, санал сэтгэгдэлд голлон тулгуурласан болно. Түүнээс гадна хэвлэлд гарсан архивын зарим баримтыг ашиглав.

Дилав хутагт Жамсранжав 1884 онд Засагт хан аймгийн Түшээ гүний хошууны (одоогийн Завхан аймгийн Түдэвтэй сум) Ойгон багт ядуу малчин Баашлуугийн гэрт төржээ. Ойгон багаас 10 гаруй өртөөний цаана орших Нарванчин хийдэд Нарванчин, Дилав гэдэг хоёр хутагт байв. Жамсранжавын мэндэлсэн жил Дилав гэгээн архины хордлогоос болж 28 насандаа өөд болжээ. Хувь тавилангийн учралаар Жамсранжавыг шинэ Дилав хэмээн тодруулжээ.

Дилав хутагтын анхны дүр Манжийн Энх-Амгалан хааны үед (1662—1723) эхлээд Өвөр Монголд (Ордост) тодорсоноос хойш Жамсранжав түүний тав дахь, Ар Монголд тодорсон гурав дахь хувилгаан байжээ. Дилав хутагт Ар Монголд тодормогц түүнийг Нарванчин хутагт урьж хийдээ хамтран эзэмших болов. Гэхдээ Дилав хутагт Ордост хоёр хийдтэй хэвээр байв.

Дилав хутагт Монголын тусгаар тогтнолын төлөө хүчин зүтгэж байсан Баруун Монголын нөлөө бүхий том лам Жалханаз хутагт Дамдинбазартай ураг төрлийн холбоотой байжээ.

Жамсранжавыг таван нас хүрмэгц Нарванчин хийдэд залж төвд бичиг заажээ. Жаал хүү ном эрдэмд гоц авьяастай байжээ. Зургаан

Ц. Пунцагноров — ШУА-ийн гишүүн

* -Дилав хутагтыг 1882 онд төрж, 1965 оны 4-р сарын 7-нд таалал төгссөн гэж бас бичсэн байдаг. ---
The Diluv Khutagt Memoirs and Autobiography of Mongol Buddhist Rein carnation in Religion and Revolution by Owen Lattimore and Fujiko Isono. 1982, Weisbaden, p. 279

насандаа хэдэн мянган шүлэг цээжилж долоон насандаа олонхийг нь монгол руу хөрвүүлж чаддаг болжээ. 11 насандаа хийдийн захиргааны ажилтай танилцаж 18-тайдаа захиргааг гартаа авчээ. Хийдийг Нарванчин хутагттай эрх тэгш захирдаг байв. Бүхий л шийдвэрийг хамтран гаргахдаа зөрөлдөж байсан удаа үгүй гэж Дилав хутагт дурсан тэмдэглэжээ.

* * *

1911 оны бороотой жил Халхын Далай Чойнхор ван Дилав хутагттай уулзаж Ар Монголыг Манжаас тусгаарлах тухай Их хүрээнд хийх чуулганд оролцох болсноо айлтгаад санал бодлоо солилцжээ. Буцаж ирснийхээ дараа дахин уулзаж Монголын тусгаар тогтнолыг зарлаж Жавзундамба хутагтыг улсын хаанаар өргөмжилсөнийг мэдэгджээ. Монгол улс байгуулагдсан нь Дилав хутагт төрийн хэрэгт үр бүтээлтэй оролцох бололцоог нээжээ.

Дилав хутагт Улиастай дахь манжийн захиргааг хүч хэрэглэхгүй зайлуулахад биечлэн оролцож 1911—1912 оны өвөл Улиастайн амбан Ма гэгчтэй хэлэлцээ хийсний дүнд манжийн түшмэдийг тэмээн хөсгөөр нутагт нь буцаасан байна.

1912 оны намар Дилав хутагт Нийслэл хүрээнд хүрэлцэн ирж Богд хаанд бараалхжээ. Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн Дилав хутагтыг засгийн газрын бүрэлдэхүүнд оруулах санал тавьжээ. Гэвч хутагт уучлалт гуйж албан томилолтыг хүлээж аваагүй юм.¹

Мөн онд Ховд хотыг манжийн захиргаанаас чөлөөлөх ширүүн тулалдаан болж монгол цэрэг ялсанаар Монголд хоёр зуу гаруй жил ноёрхсон манжийн дарлалын сүүлчийн цайз нурсан билээ.

Монголчууд бүрэн тусгаар тогтнох шаардлагыг хүчтэй тавьж ирсэн боловч 1915 онд Хиагтын гурван улсын гэрээгээр Монголд зөвхөн автономит эрх олгосныг Дилав хутагт улс төрийн дуртгалдаа харамсан тэмдэглэжээ.² Гэрээ байгуулсаны дараа Хятадын талыг баримталсан шанзув Бадамдоржийн нөлөө өсч Сайн ноён хан Намнансүрэнгийн байр суурь суларсаныг дурдахын хамт дотоод яамны сайд да лам Цэрэнчимэд Монголын тусгаар тогтнолын төлөө тууштай бөгөөд идэвхтэй тэмцэгчдийн нэг байсан юм гэжээ.

Монгол улс байгуулагдсаны дараа Хужирбуланд цэргийн сургууль нээж орос сургагч нар 800 орчим цэрэг бэлтгэсний ач холбогдлыг цохон тэмдэглэсэн байна. Монголын цэрэг улс орныхоо хил хязгаарыг батлан хамгаалахаар удаа дараа хөдлөхөд Дилав хутагт заримд нь оролцож байв.

1917 онд Хатанбаатар Магсаржав Өмнөд хязгаарыг засан тохинуулах сайдаар томилогдоод 1200 цэрэгтэй 4 хороог захиран мордоход Дилав хутагт цэргийн ламаар түүнтэй хамт явжээ. Улс орныг батлан хамгаалах хэрэгт гавьяа байгуулсан учир Богд хаан Дилав хутагтыг шар жолоо, шар хүрмээр шагнажээ.

1918 онд Хатанбаатарыг баруун хойд хязгаарыг засан тохинуулах сайдаар явуулахад Дилав хутагтыг дэд сайдаар нь томилжээ.

1919 онд Монголын дотоод, гадаад байдал түгшүүртэй болсон тухай Дилав хутагт улс төрийн дуртгалдаа дэлгэрэнгүй өгүүлжээ. Мөн оны хавар Сайн ноён хан Намнансүрэн 40 насандаа таалал төгсчээ. Зуны улиралд халх 4, Ховдын 2 аймгийн том лам, ноёд цуглаж даншиг (бат оршил) өргөх үеэр Орос улсад цагаан хааныг халсаны дараа шинэ нам хүчээ авч улмаар үймээн самуун дэгдэж байгаа нь Монгол

1—The Diluv Khutagt. Memoirs and Autobiography, p, 166

2—Мөн тэнд 80-р талд

орныг ч хамарч болзошгүй гэсэн яриа гарч аль улсаас тусламж гуйхыг улсын хурлаар хэлэлцэхийг санал болгожээ. Дээд хурлын олонхи гишүүд консул Чен И-тэй зөвлөж Хятадаас тусламж гуйхыг санал болгоход зөрөлдөөн гарч Засагт хан Цэрэнгомбожав: улаантан ирэх нь тодорхойгүй байна. Харин хятадууд ирнэ гэвэл би зөвшөөрөхгүй гэж шууд хэлжээ. Доод хурал бичиг, цэргийн түшмэдийн санаа бодлыг илэрхийлэн хятадууд биднийг дарлана. Богд хаан л шийдэг гэжээ.

Ийм нөхцөлд хятадын генерал Сюй Шүжен 1919 оны намар Нийслэл хүрээг цэргийн хүчээр эзлэн аваад Богд хаант Монголын автономит төрийг устгажээ. Хятадын түрэмгийлэл Монгол орныг донсолгов. Улс орноо харийн булаан эзлэгчдээс авран хамгаалах хөдөлгөөн нийгмийн бүх давхрааг хамарч гаднын тусламж дэмжлэг эрж сүвэгчлэх болжээ. Хаанаас дэмжлэг хүсэх вэ?, Хэнийг түшиглэх вэ? Энэ асуудлаар санал хуваагдаж байв. Монголын дэвшилт хүчний төлөөлөгчид (сэхээтэн, бичиг цэргийн түшмэд гэх мэт) Орос оронд болж буй хувьсгалт үйл явдлын нөлөөгөөр Зөвлөлт Орос улсаас тусламж авах нь зүйтэй гэж үзэж байв. Жалханз гэгээнээр толгойлуулсан хэсэг ноёд, том лам нар «баян бөгөөд хүчирхэг» Америк улсаас дэмжлэг авахаар тохиролцов. Дилав хутагт энэ хэсэгт хамаарч байв. Хэрэв Америк улс Монголыг дэмжвэл Хятадын засгийн газар түүнийг эсэргүүцэж чадахгүй гэж тэд тооцоолжээ.

Нөгөө талаар Цогт Бадамжав зэрэг цөөхөн хүн Америк улс алс хол оршдог, Японоос тусламж гуйвал хялбар бөгөөд хурдан бүтнэ гэж ятгаж байв. Гэвч Япончууд Солонгосыг хэрцгийгээр нухчин дарж байгааг сонссон монголчуудад энэ санал таалагдахгүй байв.

Жалханз хутагт Дамдинбазар Америкаас тусламж гуйх тухай саналыг Богд хаанд айлтгахад хаантан уг саналыг сайшааж өөрийн нь хэлэлцээ хийгтүн гэжээ. Жалханз хутагт, Америкийн «Андерсен-Мейер» пүүсийн төлөөлөгч Ларсонтой санал солилцоод 1920 оны өвлийн эхний сард худалдаачны автомашинаар Бээжин орохоор нууцаар мордоод өвлийн дунд сард Нийслэл хүрээнд буцаж ирсэн тухай Дилав хутагт өгүүлжээ.* Мөн тэр үед Дилав хутагтыг Америкийн Нэгдсэн Улстай харилцаа тогтоох ажилд оролцуулжээ.

1921 оны хаврын дунд сард Жанчхүү дахь АНУ-ын консул Эберхардт Монголын байдалтай танилцахаар Нийслэл хүрээнд хүрэлцэн ирэхэд нь Жалханз хутагт түүнтэй уулзаж Америкаас дэмжлэг гуйж байгааг амаар мэдэгдэв. Дараа нь Жалханз хутагт, Дилав хутагт хоёр голлон Ар Монголын автономит эрхийг сэргээх шаардлагыг үндэслэсэн Богдын бичгийг шөнөжин боловсруулж өглөө нь Богдын тамга даруулж америкийн дипломатын сууж байсан байранд Жалханз хутагт очиж гардуулжээ. Хэлмэрчийн үүргийг америкийн Андерсен-мейерын худалдааны пүүсийн Франц Ларсон гүйцэтгэж байв.

Удалгүй Сокобин гэгч америкийн бас нэг дипломат Нийслэл хүрээнд ирэхэд Дилав хутагт уулзаж дэмжлэг хүссэн Богдын бичгийг дахин гардуулав.

1920 оны зун Дилав хутагтыг Бээжинд явуулсан Жалханз хутагт тэргүүтэй Монголын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оруулжээ. Дилав хутагт энэ аялалын тухай дэлгэрэнгүй өгүүлэхдээ төлөөлөгчдийн нэн чухал зорилго Монголын автономит улсыг сэргээхэд АНУ-ын дэмжлэг олох явдал байв гэжээ. Жалханз хутагт Бээжин дэх АНУ-ын элчинтэй, Дилав хутагт америкийн цэргийн атташетэй уулзаж ярилцаж санал солилцжээ. Мөнөөхөн Ларсон гэгч аль аль уулзалтанд орчуу-

*—The Diluv Khutagt, Memoirs and Autobiography, p, 91

лагчийн үүрэг гүйцэтгэжээ. Америкийн дипломатууд Монголын саналыг засгийн газартаа уламжлахыг амлав.

Монголын төлөөлөгчид Хятадын ерөнхийлөгч, албаны бусад хүмүүстэй уулзсан боловч ямар нэг нааштай үр дүнд хүрээгүй юм. Дилав хутагт үүний шалтгааныг төлөөлөгчдийн олонхи нь хятадын талыг баримтлагчид байснаар тайлбарлаж байна. Богд хаанаар толгойлуулсан Монголын автономит засаг төрийг сэргээх бодлого баримталдаг «бидний бүлгээс» дөрөвхөн хүнийг төлөөлөгчийн бүрэлдэхүүнд үлдээсэн байв. Төлөөлөгчдийн дотроос Хатанбаатар Магсаржавыг хассан байв* гэжээ.

Төлөөлөгчид хоорондоо үзэл бодлын эрс тэс ялгаатай байсан учир нэгдмэл үйл ажиллагаа явуулах аргагүй байжээ.

Хэрэв Америк улс дэмжлэг үзүүлэхгүй бол Зөвлөлт Оросоос авна гэсэн санаа богдод болон зарим ноёдод төрж байсныг Дилав хутагт дурджээ. Иймээс тэд АНУ-д тавьсан хүсэлтийнхээ хариуг хүлээхийн зэрэгцээ Зөвлөлт Оростой хэлэлцээ хийх замыг нээлттэй байлгаж байв.

Дилав хутагт цэцэг Шагдараар (Д. Шагдаржав) дамжуулан Хүрээний консулын дэнж дэх Бодоогоор толгойлуулсан нууц бүлгэмтэй харилцаа тогтоожээ. Бодоо, Шагдаржав нараас Орос улсад Ленин тэргүүтэй засгийн газар тогтсон тухай анх сонсжээ. Мөн тэр хоёрын хүсэлтээр Дилав хутагт Зөвлөлт Оросын засгийн газраас тусламж гуйсан богдын тамгатай бичиг авч өгнө үү гэж Жалханз хутагтад хандахад: «Оросоос өөр түшиглэх газар олдохгүй байхдаа...» гэсэн боловч «хятад мэдвэл цөм үхнэ... Би айлтгахад айн татгалзах зүйл бий» гэжээ.*

Дилав хутагт Хатанбаатар Магсаржавтай хамт нууц бүлгэмийн үйл ажилд идэвхтэй дэмжлэг үзүүлж, ноёд, дээд лам нар хятадын түрэмгийлэгчдэд хэрхэн хандаж байгаа тухай тогтмол мэдээлж Улиастайн сайд Цүлтэмтэй захидлаар харилцаж туслалцуулах хүн ирүүлж байв. Дилав хутагт Богд гэгээнд бараалхаж хоёулаа үлдээд хятадын гараас гарахад Америк, Орос хоёрын аль нь түргэн туслахыг асуухад Орос туслана гэж хэлснийг хувьсгалт байгууллагынханд дамжуулжээ.

Хатанбаатар Магсаржав, Дүйнхэрийн да лам нар Зөвлөлт Орос улсаас тусламж гуйсан Богдын тамгатай бичиг авах гэж оролдсон боловч түүнийг хойшлуулсан байв. Эцсийн бүлэгт 1920 оны 7-р сард Жамъян гүн, да лам Пунцагдоржтой хамт Богдод бараалхаж Зөвлөлт, Оросоос тусламж хүссэн МАН-ын бичигт Богдын тамгыг даруулж Бодоо, Чойбалсан, Цэцэгшагдар, Сүхбаатар, Данзанхорлоо (Данзан), Догсом, Чойжин, Лосол нар хойшоо явжээ. Тэд эхлээд Оросын тусламжтайгаар Хятадын цэргийг хөөн зайлуулж Богдыг тусгаар тогтносон Монгол улсын хаан хэвээр үлдээх зорилготой байв. Оросууд Монгол ардын нам байгуулахгүй юм бол цэрэг, зэсгээр туслаж чадахгүй гэж мэдэгдсэнийг Дилав хутагт дурдатгалдаа тэмдэглэжээ.

Гамингийн харгислал ширүүсч Жигмид, Гомбоидшин, Жамъян нар баригдахад Дилав хутагт чөлөө айлтгаж нутаг буцжээ.

1920 оны сүүлчээр барон Унгерн Нийслэл хүрээг гамингаас булаан авч Монголын автономит хаант улсыг сэргээж» Жалханз хутагтыг ерөнхий сайд болгожээ. Тэр үед Засагт хаан өөрийгөө Улиастайн сайдын тушаалаас чөлөөлөхийг хүсэж Дилав хутагтыг сайдаар томилох санал тавихад жалханз хутагт ёсоор болгожээ.

Дилав хутагт ардын засаг тогтох хүртэл Улиастайн сайд байжээ.

1 - The Diluv Khutagt, Memoirs and Autobiography, p 162

*«Үнэн» Дилав хутагтын учирлал, «Үнэн» 1990. XII. 9. № 288, 3-р талд

«Улаантны үймээн эхлэхэд би огцров. «Хязгаарын сайдын үүргийг Жалханз хутагт гүйцэтгэх болов гэж Дилав хутагт бичсэн байна.»

* * *

1921 онд улаантан Хүрээг эзэлсний дараа байдал нарийн төвөгтэй болсныг Дилав хутагт дурсамжиндаа тэмдэглэжээ.

Нэгэн өдөр Хүрээнээс гурван хүн ирж Улиастайд намын үүр байгуулахыг хүсчээ. Гэтэл тэднээс баримт бичгийг нь шаардахад үзүүлэх юу ч үгүй байв. Дилав хутагт: «Би аливаа шинэ засгийг эсэргүүцэхгээгүй. Гэвч бичиг баримтгүй яваа та нарт хэрэг явуулахыг зөвшөөрч чадахгүй» гэжээ.¹ Улиастайд намын хүмүүсийг очиход хайхарч үзээгүй гэсэн ялыг Дилав хутагтад хожим тулгажээ.

Удалгүй «Улаантны удирдагч» Дамбадорж 16 хүн дагуулаад Улиастайд иржээ. Дилав хутагт тэднийг ямар зорилготой ирснийг нь мэдэх гэж гурван түшмэд явуулахад Дамбадорж тэднийг ташуурджээ. Маргааш нь Дамбадорж өөрөө ирж Дилав хутагтад хүндэтгэл илэрхийлэхэд «Та яагаад миний явуулсан түшмэдийг зодсон бэ» гэж асуухад юу ч хэлэлгүй Нийслэл хүрээ орохоор морджээ.² Мөн энэ үед «чухал улаантан» жанжин Пунцаг зэвсэглэсэн хэдэн зуун хүнтэй хүрэлцэн иржээ. Тэр хүн үе залгамжилсан ноёдтой хатуу ширүүн авирласан боловч шүтлэгтэй байсан учир Дилав хутагт болон өндөр мяндаг тушаал бүхий лам нартай тун зөөлөн харилцжээ. Баруун Монголыг цагаантнаас чөлөөлөх тулалдаан болж байх үед Чойбалсангаас бичиг хүргүүлсэнийг Хатанбаатар надад үзүүлсэн гэж Дилав хутагт дурджээ.³

Ардын хувьсгал орон даяар ялсаны дараа Дилав хутагт шинэ засгийн бодлогыг ойлгохгүй байна гэдгээ тайлбарлан огцрох бичгийг ардын засгийн газарт илгээжээ. Засгийн газрын Данзан Улиастайд ирэхэд нь өөрийн хүсэлтийг дахин тавив. Эхлээд огцруулахаас татгалзсан боловч Улиастайн сайдаар Ламзавыг томилж Дилав хутагтыг дэд сайд болгов.

Баруун Монголд цагааны самууныг дарах хэрэгт зүтгэснийг нь ардын засгаас үнэлж Дилав хутагтыг Самидий багшаар өргөмжилж, тамга, жуух олгожээ.

Тэрээр 1923 оны намар Улиастайн сайдыг түр орлож байхдаа сайдын яамыг Худгийн ам хэмээх газар суурьшуулжээ. Мөн онд харилцан туслалцах хоршооноо 50 лан хандивлаж гишүүнээр нь элссэн байна. 1924 оны зун Дилав хутагт Улиастайн сайдын яаманд дуудаг дан алба хааж байгаад бүрмөсөн халагджээ.

1920-иод онд цаг тайван байгаагүй. Хуучны ёс дэглэм өөрчлөгдөн өндөр албан тушаалтан, том ноёд алга болсоор байв. Хятадуудтай харилцаа тогтоох гэсэн хуйвалдааныг илрүүлж байв. Ийм ч учраас маш болгоомжтой байх, өөрийн үйл ажлыг гагцхүү шашны хэргээр хязгаарлахаас өөр аргагүй болов гэж Дилав хутагт бичсэн байна.⁴

Хутагт 1927 онд Мүгдэн хотноо очиж Банчинбогдтой уулзах зөвшөөрөл авахаар хийдээсээ Улаанбаатар оржээ. Нийслэлд сар гаруй болсоны дараа дотоодыг хамгаалах газрын дарга Хаянхярваа хятад улсад самуунтай байгаа учир улс төрийн байдал сайжиртал аялалаа хойшлуулахыг зөвлөжээ.

Дилав хутагт Нийслэлд байх хугацаандаа ерөнхий сайд Амар, цэргийн яамны сайд Жадамбаа, «хуучин нөхөр» Чойбалсан, эрдэмтэн

* The Diluv Khutagt, Memoirs and Autobiography p, 167

1 The Diluv Khutagt. Memoirs and Autobiography p. 167

2 Мөн тэнд. 169-р талд

3 «Үнэн» 1990. 12. 9 № 288, 4-р талд

4 The Diluv Khutagt. Memoirs and Autobiography p. 167

Жамсрангийн Цэвээн нартай уулзаж байжээ. Мөн улаан цэргийн клуб, МАХН, МХЗЭ-ийн Төв Хороодод болон нисэх онгоцонд зориулж мөнгө төгрөг хандивлаж байв. Х.Чойбалсан Дилав хутагтыг Улиастайн цэргийн сургуулийг шалгах даргын машинд суулгаж гэрт нь хүргэж өгчээ.

1928 онд Намын Төв Хороо, Дотоод яамны хоёр хүнээр толгойлуулсан феодал, ноёдын өмч хөрөнгө хураах комисс Нарванчин хийдэд ирж Дилав хутагтын байшин барилгыг лацдав. Дилав хутагт бур 1925 онд өөрийн мал сүргийг (адуу 2500, тэмээ 300 гаруй, үхэр 600 гаруй, хонь 7000 орчим) сүм хийдэд шилжүүлсэн байв. Түүнээс хойш 1925—1929 онд мөргөлчин, сүсэгтнээс тэмээ 36, хонь 700 гаруй, адуу 135, үхэр 50—100-ыг хутагтад бэлэглэсэн байжээ. Хөрөнгө хураах комисс Дилав хутагтаас хураасан мөнгийг 200000 гаруй лангаар үнэлжээ. Хутагт өөртөө 6 үхэр, 7 морь, 20 хонь үлдээж авчээ.

Лувсаншарав, Лувсанжамбаа нарын толгойлсон хөрөнгө хураах Комисс ядуусыг цуглуулж Дилав хутагтаар үг хэлүүлж хэлсэн үгий нь өөрөөр нь бичүүлэн авчээ. Дилав хутагт хөрөнгийг шинэчлэн хуваарилсныг ёс суртахууны үүднээс сайшаасан нь ангийн тэмцлийн утга учрыг гуйвуулж байна гэж зарим удирдах хүн үзэж байжээ. Тиймээс ч хутагтыг Нийслэлд дууджээ. Улаанбаатарт ирээд засгийн газар, дотоод яам зэрэг газраас асуухад дуудсан эзэн олдохгүй байв. Намын төв хорооны нарийн бичгийн дарга Бадрахтай уулзахад «одоо юм бүхнийг хамтран хороодоор шийдвэрлэдэг болсон тул би хувиасаа танд юу ч хэлж чадахгүй» гэжээ.* Энэ үед МАХН, МХЗЭ-ийн хооронд шашинд хэрхэн хандах асуудлаар санал зөрөлдсөний улмаас байдал түгшүүртэй болж маш их айж байснаа Дилав хутагт тэмдэглэжээ.

1930 оны 6-р сарын 15-нд Дилав хутагтын суудаг хашаанд дугуй унасан зарлага ирж дотоодыг хамгаалах газрын зарлан дуудах бичгийг гардуулсан байна. Хүрээд очтол нь Галиндэвэр (Галиндэв) гэдэг залуу:

— Та Эрэгдэндагвыг таних уу? гэсэн асуултаар байцаалтаа эхлэв. Үүнээс хойш олон өөр хоног, заримдаа шөнө дунд хүртэл байцаах болжээ.

Эрэгдэндагва нарын хэргийг таслан шийтгэх шүүхийн хурлыг нээх өдөр Дилав хутагт дулаан хувцаслаж ардын цэнгэлдэх хүрээлэнгийн бөмбөгөр ногоон байшинд хүрээд очиход тусгай өрөөнд Манзшир хутагт. Егүзэр хутагт нар байж байв.

Гурван хутагтыг гэрчийн этгээдээр тус хуралд оролцуулахаар ирүүлсэн байжээ. Гэвч хэрэг бишдэж тэднийг ялтан этгээд хэмээн үзэж дайчлан баривчлах шийдвэр гаргасныг шуухийн хурлын дарга мэдэгдээд өмгөөлөгчөөр Намсрайг томилжээ. Ингээд Дилав хутагт хувьсгалын эсэргүү «38-ын» буюу Эрэгдэндагва нарын хэргийг таслах шүүхийн хурлын ялтны суудалд суусан байна.

Дилав хутагтыг байцаасан өөр ерөнхий сайд Жигжиджав, Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Гэндэн, Лувсаншарав, дотоодыг хамгаалах газрын дарга Элдэв-Очир, цэргийн яамны сайд Дэמיד нар шүүхийн хуралд ирж суув. Гадагшаа гараад буцаж явтал нь хаалганы дэргэд зогсож байсан нэг хошууны Элдэв-Очир зургий нь авсан тухай хутагт дурсжээ.

Хувьсгалт шинэ засаг, МАХН-д хэрхэн ханддаг вэ? гэж Дилав хутагтаас асуухад «олон түмний тусын тулд үйлдсэн аливаа явдлыг сайшаан дэмждэг» гэж хариулжээ. Банчин богдыг ямар хүн гэж үздэг вэ?

гэхэд нь Монголд халдан довтлох цэргийг Хятад улсад цуглуулж байгаа учраас муу хүн гэж үздэг гэжээ.

Хувьсгалын эсэргүү бүлэгтэй харилцаа холбоо тогтоосон гэж ял тулгасныг Дилав хутагт хүлээж аваагүй юм.

Дилав хутагт өмгөөлөгч Намсрайн тухай бичихдээ: «Өмгөөлөгч Намсрай маш чадвартай хүн байсан бөгөөд надад ихээхэн тус болсон юм гэжээ.*

Хожим Намсрай япончуудтай далд харилцаа тогтоосон бүлгийнхэнтэй холбоотой гэж сэжиглэгдэх болсон тул тэрээр 1937 оны хавар БНМАУ-аас дүрвэн гарчээ.

1939 онд Намсрай Өвөр Монголд Дилав хутагттай уулзаж нэг хэсэг хамт байжээ. Дилав хутагт япончуудаас дайжиж Чунцин хот ороход Намсрай Өвөр Монголд үлджээ. «Япончууд Намсрайг Ар Монголын нууц тагнуул байсан гэж үзээд 1944 онд цаазалсан» гэж Дилав хутагт бичсэн байна.¹

Байцаалт дуусч байх үед Дилав хутагт үг хэлэх зөвшөөрөл авч улс орны дотор болж байгаа үйл явдлын талаар бодол санаагаа илэрхийлжээ. Ядуу, дунд ардыг хамгаалах зорилготой шинэ засгийн газрын бодлогыг зөвшөөрч байна. Нөгөө талаар бодохул язгууртан, баячууд тэдний нэгэн адил Монгол үндэстний салшгүй хэсэг шүү дээ. Ийм учраас хэргэм зэрэг, эд хөрөнгөтэй байсан хэмээн тэднийг элдвээр доромжлон дайрах нь ёсонд үл нийцнэ. Хууль зөрчсөнийг яг тогтоохоос нааш нэг ч монгол хүнийг яллах буюу шийтгэх ёсгүй гэсэн утгатай үг хэлжээ.²

Улсын яллагч «чадвартай залуу хүн» Ядамсүрэн 10 яллагдагчийг цаазаар авахыг шаардав. Тэдний дотор гурван хутагт оржээ. «Надад цаазаар авах ял оноогдуулна гэж бодож байсан болохоор би нэг их гайхаагүй» гэж Дилав хутагт бичжээ.³

Шүүхийн дарга тогтоол уншихад хоёр хутагтаас бусад 8 хүнийг 24 цагийн дотор буудан алах, Манжшир хутагтыг 10 жил, Дилав хутагтыг 5 жилээр гянданд хорихоор заажээ. Мөн хурлаас хоёр хутагтыг тэнсэнгээр суллажээ. «Харуулын дарга.., нэрсийг маань асууж лавлаад одоо явж болно гэв, Хаашаа явах юм бэ? гэхэд дуртай газраа Явахгүй юу гэжээ»⁴

Суллагдсанаас хойш Дилав хутагт, өөрийн нь бичсэнээр, өмнө зүгт дүрвэхээс өөр юм бодохоо больжээ. Эрт, орой нэгэн цагт дахиад баригдана гэдэг бол тэнсэнгийн болзлоор цаазаар авахуулна гэсэн үг байв. Өвөр Монгол хүртэлх аялалын бэлтгэлийг нутаг буцах халхавчийн дор хийжээ. Нийслэлийн орчим янз бүрийн айлд хадгалуулсан малаа борлуулж хятад мөнгөн янчаан олж бэлтэй болжээ. Ингээд таван хүнтэй тэмээн цуваа алсын замд хөдөлжээ.

Улаанбаатараас Нарванчин хийд орох Хангай болон Говийн хоёр зам байжээ. Тэд говийн замыг барьж дөрөв хоног явж байгаад урагшаа эргэн Дунд гүний хошуугаар дамжин цагаан сарын 20-ны саргүй

* The Diluv Khutagt. Memoirs and Autobiography ... p. 203

1 The Diluv Khutagt. Memoirs and Autobiography ... p. 203

2 Мөн тэнд 206-р талд

3 Мөн Тэнд 208-р талд

4 Мөн тэнд 210-р талд

2 Японы түрэмгийллийн аюул занал хурцадсан НӨХЦӨЛД ардын засгаас Дилав хутагтын эх оронч сэтгэл, шударга зан байдлыг харгалзан түнд даалгавар өгч Өвөр Монголд дүрвэх бололцоо олгосон тухай мэдээ хэвлэлд гарсан. Үү нийг цаашдаа улам тодруулах ёстой гэж бодож байна. («Үнэн», 1990, XII, 09 № 288, 3-р талд)

шөнө хил давжээ. Хилийн манааны нохой хуцах чимээ дуулдаж эгшин зуур гэрэл сүүмэлзээд алга болов. Ийнхүү Дилав хутагт эх нутгаасаа гарч хүний газар нэвтрэн оржээ.

Дилав хутагтын өөрийн нь ярьсан намтар энэ үеэр төгсчээ.²

* * *

1931—1964 он бол Дилав хутагтын хувьд маш хүнд жилүүд байсан нь мэдээж юм. Олон улсын хурцадмал байдал, гоминьданы Хятад эзэрхэг түрэмгий Японоос БНМАУ-ын талаар явуулж байсан бодлого, дэлхийн хоёрдугаар дайны дараахь «хүйтэн дайн» энэ бүхэн Дилав хутагтыг тойрч өнгөрөөгүй билээ. Гэтэл хутагт энэ үеийн тухай дурсамжаа үлдээсэнгүй нь харамсалтай. Энэ үед ялангуяа Хятад улсад яаж амьдарч байсныг нь харуулах баримт сэлт одоогоор ховор байна. Дилав хутагтын намтарт зарим бүдэг балархай зүйл бий ч гэсэн тэрээр харь оронд цагаачийн зовлон бэрхшээлийг туулж байхдаа Монголоо гэсэн зориг санаанаасаа няцаагүй гэдгийг гадаадад амьдарч байсныг нь сайн мэддэг О. Латтимор гэрчиж байна. Латтимор 1930—1931 оны өвөл Бээжинд түүнтэй анх танилцаж түүнээс хойш 1964 онд Нью-Йоркт нас барах хүртэл нь ойр дотно харилцаатай байжээ.

Японы түрэмгийлэгчид Зүүн хойт Хятадыг эзлэж «Манжго» гэгч тоглоомын улс байгуулаад улмаар БНХАУ-д халдан довтолхыг завдаж байсан үед Дилав хутагт ямар байр суурь баримталж байсан бэ? О. Латтиморын бодлоор Дилав хутагт нэгдүгээрт, өөрийгөө юуны өмнө шашны төлөөлөгч гэж үзээд японы түрэмгийлэгчдэд ашиглагдахгүйг хичээсэн; хоёрдугаарт, БНМАУ-ын дотоод бодлого, түүний гадаад улс төрийн байдлыг хооронд нь ялган салгаж байв; гуравдугаарт, өөрийн орны болон Өвөр Монголын туршлагаас үндэслэн хятадын цэргийн эрхтнүүд ноёрхож байгаа цагт Монголын ирээдүйд найдаж болохгүй гэсэн ойлголттой байжээ.

Дилав хутагт Өвөр Монголын улс төрийн зүтгэлтэн Н. Дэмчигдонровтой (Дээ ван) 1931 онд Бээжинд танилцаж олон жил харилцаатай байв. Дэмчигдонров «монгол үндэстнийг нэгтгэхэд АНУ-ын дэмжлэгийг хүссэн захидлыг Дилав хутагтаар дамжуулан О. Латтиморт явуулсан байна.¹

Дилав хутагтыг Өвөр Монголд дүрвэсний нь дараа японы цэргийн эрхтнүүд түүнийг өөртөө татахыг оролдсоор иржээ. Хурандаа Мацумуро «Монгол улсыг байгуулах тухай» 1933 оны 10-р сард боловсруулсан саналдаа Дилав хутагтыг тэр тоглоомын улсын «тусгаар тогтнолын төлөө цэргийн» жанжнаар томилохоор төлөвлөж байв.² Япончууд Бээжинг эзэлсний дараа 1930-аад оны сүүлчээр Дилав хутагтыг Японд урьж хүндэтгэн зочилсон боловч тэрээр Японоос ямар нэгэн томилолт хүлээн авахаас зайлсхийжээ.

Дилав хутагт Японоос Бээжинд эргэж ирсэнийхээ дараа Шанхай орж тэндээс далайгаар Гонконг хүрч улмаар Чунцин хотыг зүглэжээ. Чан Кайшигийн засгийн газар түүнийг Монгол-Төвдийн хэрэг эрхлэх комиссын товчооны өндөр тушаалд томилжээ. Энэ үед О. Латтимор Чан Кайшийн зөвлөхөөр томилогдоод 1941 онд Чунцинд хүрэлцэн иржээ. Дилав хутагт түүний хүсэлтээр 1942 онд нутаг буцах хүртэл нь нэг байранд хамт амьдарч байв. 1944 онд Латтимор АНУ-ын дэд ерөнхийлөгч Уоллесаг дагалдан Чунцинд дахин ирэхдээ Дилав хутагттай бас уулзжээ.

Удалгүй Дилав хутагт Энэтхэгээр дамжин Төвд орж бяцхан далай ламын гэр орныхонд болон шадар хүмүүст нь итгэмжлэгдсэн зөвлөгч

1— «Ил товчоо» 1991 оны 1-р сарын 11-12, № 2, 6-р талд

2 The Diluv Khutagt. Memoirs and Autobiography . . . p. 161

болжээ. Хятад улсад иргэний дайн гүнзгийрч Төвдийн асуудал нарийн түвэгтэй болсон учир Төвдийн эрх баригчид Дилав хутагтыг Нанжин буцахыг зөвлөсөн байна.

Дилав хутагт 1949 онд Нанжингаас О. Латтиморт бичсэн захидалдаа Чан Кайшийн дэглэм мөхөх цаг ойртсон болохоор Төвдийн Лхаст эргэж очих санаатай байгаагаа мэдэгджээ. Хариу захидалдаа О. Латтимор түүнийг АНУ-д айлчлахыг урьж «Бурханаас заяасан хүү» нь хүлээж байгааг цохон дурджээ. «Бурханаас заяасан хүү» гэдэг нь Дилав хутагтаас Батбилэг гэж монгол нэр хайрласан Латтиморийн хүү Дэвид байв.

Мөн оны эхээр Дилав хутагт АНУ-д хүрэлцэн очив. Тэр үед Балтимор хотын Жон Хопкинсын их сургуульд ажиллаж байсан О. Латтимор монгол хэл, нийгмийн байдлыг хослон судлах хөтөлбөрөөр семинар зохиож эхэлсэн юм. Судалгааны үр бүтээлийг нэмэгдүүлэхийн тулд цөөхөн Ар, Өвөр Монголчуудын бүлгэм байгуулж түүнд оролцсон хүмүүсээр тус тусынх нь намтар, нутаг орны нь байдлын тухай хураангуйлсан илтгэл бэлтгүүлдэг байжээ. Дилав хутагт энэхүү семинарт идэвхтэй оролцож залуучуудтай ажиллахын зэрэгцээ улс төрийн дуртгалаа бичжээ. Түүнээс гадна Нарванчин хийдийн тухай өгүүлэл бичиж газрын нь зургийг санаагаараа үйлдэн хавсаргажээ.

Дилав хутагтын улс төрийн дурсгал, намтар хоёрын анхны төслийг 1949 оны хавар боловсруулсан байна. Улс төрийн дуртгалыг Дилав хутагт өөрөө зохион бичжээ. Харин намтарыг нь тэмдэглэж авахад О. Латтимор оролцов. Тэрээр хутагтад хандаж бурханаас заяасан хүү Батбилэгээ дэргэдээ суулгаж байгаад өөрийнхөө тухай хэлэх гэсэн бүхнээ ярихгүй юу. Таныг ямар хүн байсныг төдийгүй хэн болохыг тань мэдэг гэхэд Дилав хутагт зөвшөөрчээ. Дилав хутагт хивс буюу монгол эсгий дээр тухлан сууж өнгөрснийг эргэн санаж дурсан ярихад Латтимор англи руу тэр дор нь орчуулж хүү нь тэмдэглэн авлаг байжээ. Хутагтын яриаг дундуур нь таслахгүй байх, байцаагдаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхгүй аль болох энгийн чөлөөтэй яриулахыг Латтимор хичээжээ. Ингэж ажилласны үрээр Дилав хутагтын намтар үйл амьдралыг нь үнэн бодитойгоор харуулсан баримт бичиг үлджээ. Үүгээрээ Дилав хутагт Монгол судлалд жинтэй хувь нэмэр оруулсан билээ.

1950-иад оны эхээр АНУ-д Маккартийн харгислал ноёрхож байсан тэр үед О. Латтимор эх нутгаа орхиж Английн Лидс хотын их сургуульд ажиллах болов. Түүний АНУ-д зохион байгуулсан Монгол судлалын семинар ч хаагдав.

Дилав хутагт буддизмыг сонирхдог америк анд нөхдийн дэмжлэгээр Нью-Йорк хотноо амьдрах болов. Нью-Жерси муж улс, Филадельфия хотод оршин суудаг халимагийн цагаачид Дилав хутагтыг жинхэнэ хувилгаан хэмээн бишрэн шүтэж нэг хуучин гарашийг сүм болгон тохижуулжээ. Ийнхүү Дилав хутагтын нөлөөгөөр АНУ дахь шарын шашны гал голомт бэхэжсэн байна.

Дилав хутагт Өрнөдийн зарим орон болон БНМАУ-ын хооронд шинжлэх ухаан, олон нийтийн харилцааг үүсгэн хөгжүүлэхэд оролцож америк-монгол, англи-монголын нийгэмлэгүүдийн хүндэт гишүүн байв.

1961 онд БНМАУ-ыг Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүнээр элсүүлэхэд ная шахсан Дилав хутагт Ерөнхий Ассамблейн хурлын танхимд ажиглагчийн байранд сууж байсан билээ. Манжийн засаглал, Монголын хаант улс, ардын засаг-ийм гурван төрийн нүүр үзсэн хүмүүсээс тусгаар тогтносон Монгол улсыг нийтээр хүлээн зөвшөөрснийг нүдээрээ үзсэн цорын ганц хүн нь Дилав хутагт байлаа.

Богд хаан ардын хувьсгалаас өмнөхөн хэсэг ноёд, дээд лам нар-

тай уулзаад хамгийн залуу нь хэн бэ гэж асуухад нэг л хүн Дилав хутагтаас ах байв. Тэгэхэд нь халмагдуу байсан Богд: -Та нар бүгдээрээ буруу хэлж байна. Хамгийн залуу нь Дилав гэж хэлсэн нь нэг ёсны зөн билгийн үг байжээ. Энэ хүмүүсийн дотроос одоо би л ганцаараа амьд явна гэж Дилав хутагт бичсэн билээ.*

1964 онд О. Латтиморын Лидст байхад Дилав хутагт хорт өмөн үү өвчний улмаас нас эцэслэх ойртлоо гэсэн цахилгаан утсыг хүү Дэвид нь ирүүлжээ. Тэр даруйд нь Нью-Йоркт нисэн очиход хутагтын бие сул боловч зовуурьгүй байв. Латтиморийн гэргийн амар амгаланг асууж тэдэнд сайн сайхныг ерөөжээ. Америкийн эрдэмтэн ойролцоо оршдог Нью-Хэвн хот очоод ирэх хооронд Дилав хутагт таалал төгссөн байжээ.

Дилав хутагтын шавь нартаа захисан ёсоор цогцосыг нь чандар болгож төрсөн нутаг -БНМАУ-д хүргэсэн билээ.

* The Diluv Khutagt. Memoirs and Autobiography . . . p. 161